



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№117 /561/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.07.31

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧ ЦЭРГИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАР СУДАНЫ ИРГЭДЭД ТУСАЛЖЭЭ



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай UNMISS энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийнхан суданы иргэд рүү хандсан ээлжит бүтээлч ажил, сайн үйлсийн талаар НҮБ-ын хэвлэлийн төлөөлөгч онцолжээ.

Өмнөд Суданд борооны улирал эхэлсэнтэй холбогдуулан зарим төрлийн халдварт өвчнийг илрүүлж оношлох, эмчилгээ үзүүлэх зорилгоор

Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийн эмч, сувилагч, эрүүл ахуйч нараас бүрдсэн баг Бентью хотын эмнэлэгт ажиллаж, мэргэжлийн дэмжлэг үзүүлж, судан иргэдээс хумхаа болон цар тахлын шинжилгээг авсан байна.

Энэ үеэр шинжилгээгээр өвчлөлтэй гарсан иргэдэд анагаах эм тариаг, эмнэлэгт нь шаардлагатай багаж, бусад хэрэглэлийг гардуулж өгчээ. Бентью хотын эмнэлгийн дарга доктор

Банен Монголын энхийг сахиулагчдад НҮБ-ын өмнө хүлээсэн үндсэн үүргээсээ гадна энх тайван, эрүүл аюулгүй байдал, хүүхэд багачуудын ая тухтай орчин нөхцөлд үргэлж санаа тавьж, сайн үйлс өрнүүлж байдаг нь талархал илэрхийлснийг НҮБ-ын веб сайтад дурдсан байна.

Ахмад Д.БОЛОР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 9


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,435	3,443
EUR 🇪🇺	3,799	3,828
CNY 🇨🇳	483	488
RUB 🇷🇺	38	38.20
JPY 🇯🇵	24.10	24.30
KRW 🇰🇷	2.66	2.69

ЗУРХАЙ



2023.07.31 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 8

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.27-20.30

Барилдлага:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олно.

ШИЛДЭГ САЛААДЫГ ТОДРУУЛЖ, УРАМШУУЛЛАА



Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийг түшиглэн явагдаж байгаа "Оюутан цэрэг-2023" нь сургалтын төлөвлөгөөний дагуу 07 дугаар сарын 30-ны өдөр гуравдугаар шатны буудлагын дасгалыг амжилттай зохион байгуулж явууллаа. Энэ удаагийн буудлагаар байлдагч Э.Бат-Өлзий, О.Батбаатар нар мэргэн буудаж, онц буудагч гэдгээ ахин батлав. Тус өдөр рот, салбаруудыг сурталчлах хүрээнд сургалтын I ротынхон "Цэргэжлийн буухиа тэмцээн"-ийг 7 цэгт төрөл цэргийн дасгал, нормативаар зохион байгуулахад IV ротын II багийнхан манлайлж, II ротын I баг болон IV ротын I багууд удаах байруудад шалгарлаа. Мөн 07 дугаар сарын 31-ний өдөр

цэргийн алба, сургалт бэлтгэл, сахилга, зохион байгуулалтаар бусдыгаа манлайлсан тэргүүний салаадуудыг тодруулахад тэргүүн байрт дэслэгч Ц.Цогжаргал захирагчтай III ротын III салаа, дэд байрт дэслэгч М.Гасырбек захирагчтай IV ротын III салаа, гутгаар байрт дэслэгч Э.Пүрэвдорж захирагчтай I ротын I салаа тус тус манлайллаа.

Тэргүүний тасаг, салаа, ротыг тодруулах нь оюутан цэргүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, бусдын өмнө хариуцлагатай иргэн хүн болж төлөвшихөд их чухал үүрэгтэй юм.

Дэслэгч Б.ТЭНГИС



УЛСЫН ГАРАМГАЙ ХАРВААЦДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Улсын баяр наадмын Үндэсний сурын харвааны төрөлд 40 сумнаас 37 сум онож дэд байр эзэлж "Улсын гарамгай харваач" цол хүртсэн Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн алба хаагч, спортын мастер, ахлах ахлагч Мэлсийн Бат-Оршихыг анги хамт олон нь өнөөдөр ёслол төгөлдөр угтан авч, хүндэтгэл үзүүллээ.

Улсын гарамгай харваач, ахлах ахлагч М.Бат-Орших болон Дорнод нутгийн үндэсний сур харваачдыг тус ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Б.Адъяа тэргүүтэй бүрэлдэхүүн "Монгол дайчдын хөшөө" цогцолбортоо хүндэтгэлтэйгээр угтан авч, баяр хүргэв. Энэ үеэр ангийн захирагчийн сайшаалын тушаал, ахлагчийн зөвлөлийн дурсгалын зүйлийг гардуулан өгч, урлагийн тоглолтыг өргөн барьсан юм.

Хошууч Д.ГАНБААТАР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,450,990

Эдгэрсэн

Нийт: 664,310,475

Нас барсан

Нийт: 6,904,050

Цахим шууданд

ТАЛАРХАЛ



гэдгийг ам бардам хэлж байгааг минь хүндэтгэн хүлээн авна уу. Хүний мөрөөдөл хязгааргүй гэдэг билээ. Би та бүхэндээ дараагийн эрэл хайгуулын их аянд мордож байгаагаа дуулгахад таатай байгаа боловч басхүү гунигтай байна.

ЦДБЭЧ-ын найрал дууны албаны дуучин, Дэд ахлагч, МУСТА. Төмөрбаатарын Жавхланням миний бие 2023оны 07-р сарын 17-ны өдрөөс эхлэн өөрийн төрсөн нутаг Ховд аймгийн ХДТ-ын даргын үүрэгт ажилд томилогдлоо.

Надад баярлах, сандрах, айх, балмагдах зэрэгцэж байгаа хэдий ч намайг өдий зэрэгт хүргэсэн хайрт аав ээж, хань үр хүүхэд, мэдээж гайхалтай сайхан хамт олон, үргэлж зөвлөж тусалж байдаг ах нар, найз нөхөд минь байгаа болохоор би итгэлтэйгээр ийм том сонголтыг зориг гарган хийж байна.

Миний хүсэл мөрөөдөл сэтгэл зүрх үргэлж та нартайгаа хамт Эх Орныхоо төлөө шүү!! Их зүйлийг сурч мэдэж ирээд эргээд та нартайгаа мөр зэрэгцэн эх орныхоо төлөө зүтгэх тэр өдрийн төлөө үргэлж хичээж улам ихийг сурч ажиллах болно.

ЦДБЭЧ-ын дуучнаас ХДТ-ын дарга хэмээх хариуцлагатай албыг хашиж хүртэл замыг минь засаж, цаг ямагт хоёргүй сэтгэлээр тусалж дэмжсэн ЦДБЭЧ-ын удирдлага, хамт олондоо дахин талархал илэрхийлж уран бүтээлийн өрнүүн их амжилтыг хүсэн ерөөе!

ХҮНДЭТГЭСЭН: Ховд аймгийн ХДТ-ын дарга, МУСТА Т.Жавхланням

Тэртээ 2008 он юмаа ганц хүүгээ цэрэг, цагдаагийн хүн болгох юмсан гэсэн аавынхаа хүслийг сэтгэлдээ тээж, алдартай дуучин болно доо гэсэн өөрийнхөө мөрөөдлийг биелүүлэх гэж хичээн дуучин гэдэг мэргэжлийг сонгож байлаа.

2012 онд анд найзууд болох дуучин Д.Лхамхүү, дуучин МУСТА Ө.Батбаатар нарыг ЦДБЭЧ-д шалгуулж байхыг найрал дууны албаны ангийн хаалганы гаднаас сонсож зогссон СУИС-ийн дуурийн дуу дуулаачийн 4-р курсийн оюутан заавал энэ байгууллагад орж аавынхаа болон өөрийнхөө мөрөөдлийг биелүүлнэ гэж өөртөө амлалт өгч байсан хүү аль хэзээний өөрийн амлалтдаа хүрч хүсэл мөрөөдлөө биелүүлэн ЦДБЭЧ гэх их айлаар овоглон амьдарч, найрал дууны албандаа өөрийн орон зай түүхийг бичжээ.

Өчүүхэн миний өнөөдрийн бүтээсэн бүтээл гаргаж буй амжилт яахын аргагүй миний хамт олны нэр, төр, сүр, хүч юм шүү

ОЮУТАНЦЭРГҮҮДЭД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Үүний нэг нь Дорнод аймгийн Цагдаагийн газартай хамтарсан эрх зүйн сургалт бөгөөд өсвөр насны залуучуудыг өөрийгөө гэмт хэрэг зөрчлөөс хэрхэн сэргийлэх, буруу дадал зуршлаас найз нөхдөө хамгаалах зэргийг мэдээллээр хүргэлээ. Тус аймгийн Цагдаагийн газрын цагдаагийн ахлах дэслэгч Г.Ганзориг, Э.Өлзийбаярах, Н.Тэмүүжин нар цагдаагийн байгууллагын онцлог, үүрэг зорилгын талаар танилцуулга хүргэсний дараа санаатай болон санамсаргүй гэмт хэрэг, осол зөрчлөөс сэргийлэхэд иргэн бүрийн сахилга бат, хариуцлага хамгийн чухал гэлээ.

Хүн гэдэг тэнгэрийн дор төрж, хуулийн дор захирагдаж амьдардаг жамтай. Энэ жамыг зөрчсөн хэнд ч хууль үйлчилж, сахилга хариуцлагыг нь заавал хүлээлгэдэг гэж тодотгов. Цагдаагийн офицерууд цахим болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүний ял шийтгэлийн талаар мэдээлэл өгч, сонирхсон асуултад нь хариулсан юм.

Ахлах дэслэгч Х.ГАРЬД

Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Сургалтын төвд явагдаж байгаа "Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтаар түрүүч, байлдагч нарын цэргийн албаны эрдэм мэдлэгээс гадна хувь хүний хөгжил, эрх зүйн мэдлэг, хамт олонч нөхөрсөг харилцааг бэхжүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Гэрэл зураг түүх өгүүлнэ



ЦЭРГИЙН НӨХӨРЛӨЛ НАСАН ТУРШИЙНХ БАЙДАГ

БОКСЫН ТЭМЦЭЭНД "АЛДАР"-ЫНХАН ТЭРГҮҮЛЭВ



"Алдар" спорт хорооны боксын дасгалжуулагч агсан, спортын мастер, дэд хурандаа Хорлоогийн Магваны нэрэмжит боксын тэмцээн амжилттай явагдаж өндөрлөлөө.

Бага нас, өсвөр, залуучуудын ангиллаар зохиогдсон энэхүү тэмцээнд 22 байгууллагын 118 тамирчин өрсөлдсөн бөгөөд Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн өсвөр, залуу боксчид, Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг спорт хороод, клубүүдийн тамирчид оролцлоо. Спортын мастер Х.Магван агсан 1982-1999 оныг хүртэл "Алдар" спорт хорооны боксын дасгалжуулагчаар ажилласан ба "Алдар"-ын боксчид түүний удирдлага дор Монголын бүх ард түмний спартакиадад 11 удаа түрүүлж, хоёр удаа дэд байрт шалгарч байсан юм. Ийнхүү тэмцээний байгууллагын дүнгээр тэргүүн байрт "Алдар" спорт хорооны шалгарч, "Ихэр бээлий" боксын клуб, "Радианс" боксын клубийн тамирчид удааллаа.

Ахмад Ж.ОТГОНБАЯР



ОНЦ БУУДАГЧ НАР ОЛНООР ТӨРӨН ГАРАВ



Зэвсэгт хүчний 330 дугаар ангийг түшиглэн явагдаж байгаа "Оюутан цэрэг" сургалтын дайчид "Галын бэлтгэл" хичээлээр байлдааны зөвсөглөл, техникийг судалж, буудлагын дасгал гүйцэтгэлээ. Энэ үеэр 12 оюутан цэрэг мэргэн буудаж, "Онц буудагч"-аар буудлагын талбай дээр шагнагдав.

Мөн тасгийн байлдааны буудлагыг 4 тасагт "Дайсны тагнуул хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх үеийн ажиллагаа" сэдвээр амжилттай явуулсан бөгөөд галын бэлтгэлтийн хичээлийг ахмад М.Хишигсүрэн, ахлах ахлагч Б.Одсайхан нар удирдлаа.

Хошууч Э.ГАНЦООЖ